

## ОРОСЫН ГАДААД БОДЛОГО БА БИЗНЕСИЙН ХҮРЭЭНИЙХЭН

К.ДЭМБЭРЭЛ\*

Орчин үеийн Оросын гадаад бодлогод нөлөөлж буй нэг гол хүчин бол бизнесийн хүрээнийхэн юм. Ялангуяа Б.Ельцины үед нэлээд нөлөөтэй болж гадаад бодлогод тодорхойлох үүрэгтэй болсон нь Оросын түүхэнд байгаагүй шинэ соргог зүйлийн тоонд зүй ёсоор орно. Харин В.Путиныг ерөнхийлөгч болсноор бизнесийн хүрээнийхний “дураараа дургих үйл ажиллагаа” түрүү үеэ бодвол нэлээд хумигдсан. Энэ нь үндэснийхээ сонирхлыг арай түлхүү тавьсантай холбоотой болов уу. Гэхдээ үндэсний сонирхол хэмээх ойлголт маань улс төрийн шинжлэх ухаанд эргэлзээтэй болчихсон зүйл. Тэрчлэн “том бизнесийн” удирдлагад ерөнхийлөгчийн тамгын газраас зайлшгүй нэг түшмэлийн төлөөлөлтэй болж нэг ёсондоо “зээн нь юмаа мэддэг” гэдгийг харуулж өгсөн. Гэсэн хэдий ч улаан цайм төрийн зүгээс хутгалдах нь утгагүй бөгөөд түүх болон хоцорсон зүйл. Шинжээчдийн үзэж байгаагаар бол сүүлийн жилүүдэд тэдний нөлөөгөөр гадаад улс төрийн гол бодлого нь геополитикаас геоэкономикт аажмаар шилжиж байгаа гэх буюу дор хаяад аюулгүй байдал ба эдийн засгийн сонирхлын асуудлуудын хоорондын харилцаа илүү тэнцвэржсэн ажээ. Гадаад бодлого нь эдийн засаг руугаа илүү хандах болсон нь зарим талаараа түүний олон талт векторын шинжийг давхар тайлбарлаад өгч байна. Одоохондоо Оросын бизнес-элитүүд нэгдмэл сонирхолтой хараахан болоогүй байна. Энэ нь нэг ёсондоо үйл ажиллагааны нарийн хуваарь алга гэсэн үг. Зарим нэг бүлэглэлийг эс тооцвол эдийн засгийн чухал секторуудын элитүүдийн хоорондын сонирхол нь заримдаа зөрчилддөг. Тэгэвч ерөнхийдөө Оросын өргөжиж буй бизнесийнхэн хэрэглээнийхээ зах зээлээ европ, америкийн эдийн засгийн орон зайд өргөжүүлэх, шинэ технологи, хөрөнгө оруулалтын эх сурвалжтай болох гэсэн санаандаа хөтлөгдөн “баруун” тийш хандажгааж байгаа. Түүний зэрэгцээ зарим секторууд нь эдийн засаг, улс төр аль эсвэл бараа бүтээгдэхүүнийхээ чанар муугаас болж европын зах зээлд хөл тавьж чадахгүй байна. Тиймээс ч тэдгээр нь хүссэн хүсээгүй дотоодын зах зээл рүүгээ хандах шаардлагатай болсон төдийгүй протекционизмыг ч дэмжих, аль эсвэл Азийн зах зээл рүү үйл ажиллагаагаа чиглүүлэхэд хүрсэн юм.

\* К.Дэмбэрэл - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

1998 оны эдийн засгийн хямралаас хойш дотоодын үйлдвэрлэгчид, түүний дотор экспортын чиглэлтэй том бизнесийнхэнд маш тааламжтай нөхцөл бүрдсэн. Харин тэдний экспортоос орох валютыг 100% хүртэл зарахыг засгийн газраас нь хямралын дараахи эхний үед даалгасан ганц боймлолтыг эс тооцвол дотоодын үйлдвэрлэгчдийн хувьд бүхэлдээ эерэг үр дагаврыг энэ хямралаар олсон. Гэвч тухайн үед гадны хөрөнгө оруулалтаа бараг 100% алдсан.

Европын орнуудтай сайн хөршийн харилцааг эрхэмлэн хамгаалах сонирхол бүхий хамгийн хүчтэй лобби бол яах аргагүй байгалийн хийн секторынхон. Энэ нь Оросын бизнес-хүрээнийхний дотроос урт хугацааны хөгжлийн стратеги бүхий цорын ганц сектор. Хэдий тийм ч Барууныхан болон тэдний гарт буй санхүүгийн институтуудтай "Газпром"-ын дархан эрхтэй үйл ажиллагаа ТУХН-ийн орнуудтай тухайлбал, Украин, Беларусь, Туркменстантай явуулж буй "дипломат" арга хэмжээ нь түүнийг харилцан үл ойлголцолд хүргэж болох юм. "Газпром"-ын нэг жилийн эргэлт нь дунджаар 18 тэрбум америк долларт хэлбэлздэг. Европын хөгжилтэй орнууд жилд дунджаар 440 тэрбум шоо метр байгалийн хий хэрэглэдэг ба түүний 250 тэрбум шоо метрийг импортоор авдаг. Харин үүнийхээ 100 тэрбум шоо метрийг ОХУ-аас авдаг аж. 2000 оны байдлаар Европт гаргасан байгалийн хийн экспортын ашиг нь 700 сая ам.доллараас давсан(1). Мөн 2000 оны байдлаар ОХУ нь байгалийн хий болон дагалдах хийг 500 гаруй тэрбум шоо метрийг олборлосон. Европын зах зээлд 1000 шоо метр байгалийн хийг 110 ам.доллараар, Гүржид 51 ам.доллараар тус тус нийлүүлдэг.

Оросын нефтийн секторынхон болохоор өөрсдийн экспорт, хөрөнгө оруулалтын эх сурвалж болон шинэ технологоос хамаараад Европтой илүү нягт хамтран ажиллахыг эрхэм болгож байна. Учир нь тэдний үндсэн фондын 80 хувь нь элэгдэлд орчихсон. Ерөнхийдөө тэд нар байгалийн хийн сектороос дутахааргүй Баруун руу тэмүүлж байна. Ази-Номхон далайн бүс, Дундад Ази, Ойрхи Дорнод (тухайлбал Ирак) зэрэгтэй хамтын ажиллагаагаа хөгжүүлэх нь нефтийнхний хувьд мөн л чухал стратегийн асуудал.

Эрчим хүчний салбарынхан ч ялгаагүй Европ руу зүтгэж байгаа. Учир нь түүнийг "ирээдүйтэй" зах зээл, хөрөнгө оруулалтын эх сурвалж хэмээн үзэж байгаа. Түүний зэрэгцээ Азийг тэр тусмаа Хятадын зах зээлийг "РАО ЕЭС" (эрчим хүчний нэгдсэн систем) компани нь боломжийн сонирхож болох зүйлд тооцож байгаа. "РАО ЕЭС"-ын нэг жилийн эргэлт нь дунджаар 17 тэрбум америк долларт хэлбэлздэг. Дээрхи гурван салбар нь нүүрсний салбартайгаа нийлээд түлш эрчим

хүчний секторын гол зүтгүүр бөгөөд улсын төсвийн 40% бүрдүүлж, нийт экспортын 42,4% эзэлдэг. Нэг үгээр бол тэдгээр нь “Донор” салбарт тооцогддог. Хэдий тийм ч түлш эрчим хүчний салбарын үндсэн фондын 60% нь элэгдэлд орчихсон байгаа. Монгол улсын эдийн засагт гол нөлөөтэй нефть болон эрчим хүчний салбар нь үүнд хамрагдаж байгаа нь бидэнд бас нэгийг бодогдуулам. 2000 оны байдлаар нефть, конденсатыг 305 сая тонн, нүүрсийг 251 сая тонныг олборлон боловсруулсан ба 165 тэрбум квт.цаг эрчим хүчийг зөвхөн усан цахилгаан станцуудад үйлдвэрлэсэн(2).

Банкны салбарынхан, ялангуяа 1998 оны санхүүгийн хямрал хүртэл ОХУ-ын олон улсын хамтын ажиллагааг ялангуяа Европ, Америктай гүнзгийрүүлэхийн төлөө идэвхи гаргаж байсан. Одоохондоо тэрээр эдийн засаг, улс төрийн өөрчлөлтийг дэмжсэн либерал байр суурин дээрээ хэвээр байгаа. Санхүүгийн нөөцийн шаардлага нь Оросын банкуудыг хөгжилтэй орнуудтай тогтвортой түншийн харилцааг хөгжүүлэхийн түлхээс болж байна. Гэвч зарим банкууд, тухайлбал протекционист чиглэлтэй санхүү-аж үйлдвэрийн бүлэгт багтдаг илүү үндсэрхэг байр сууринаас хандаж байна.

“ВПК” буюу цэрэг-аж үйлдвэрийн секторынхан бусдыгаа бодвол илүү үндсэрхэг чиглэлтэй л дээ. Гэвч дотроо мөн л хуваагдмал байр суурьтай. Тэдний зарим нь “хуучнаа” ихэд санагалзаж байгаа. Өөрөөр хэлбэл, улсын найдвартай баталгаа бүхий байнгын тогтвортой захиалгатай, нийгэмд томоохон байр суурьтай, “сэтгэлийн шаналгаагүй” байх бодол нь ийм байдалд хүргэж байгаа. Нөгөө хэсэг нь зах зээлийн эдийн засгийн бодит хуулийг мэдрээд хөгжилтэй орнуудтай өндөр технологийн салбарт хамтран ажиллахыг урьтал болгогсод. Ерөнхийдөө “ВПК”-н генералуудыг (тухайн салбарын бараг бүх хүрээний ажиллагсад цэргийнхэнд харьяагдах ба удирдлагууд болон томоохон зохион бүтээх төвүүдийн захиралууд ч генералын мөрдөстэй) Баруунтай нягт хамтран ажиллах сонирхол бүхий бүлэгт хамруулж болохгүй гэсэн ч тэднийг хамгийн нөлөө бүхий барууны эсрэг үзэлтнүүдэл ч хамруулж үл болно. Тэдний ЗХУ-ын хуучин статусыг санагалзагчид нь прагматик бодлого бүхий хүчнийхэнд байр сууриа алдсаар байна. “ВПК”-н хүрээнд 1700 гаруй томоохон үйлдвэрүүд багтдаг ба 1999 оны байдлаар “ВПК” нь ОХУ-ын машин механизм үйлдвэрлэлийн 32%, тэр чиглэлийн экспортын 35% тус тус гаргаж уг наймаанаас тухайн жилдээ нийт 120 сая ам.долларын ашиг олсон мэдээтэй.

“ВПК”-той адил байр суур нь тодорхой бус нэгэн элит нэгтгэл бол “МИНАТОМ” буюу ОХУ-ын Атомын эрчим хүчний яам юм. Баруун

Европын орнуудын тухайлбал, Франц зэргийн хатуу протекционист бодлогын улмаас, Дорнод болон Төв Европт, мөн Дорнод Германы атомын программ хаагдсаны зэргээс байр суурь нь алдагдсан тэд “амьдрахын эрхээр” шинэ зах зээлийг Азид болон Ойрхи Дорнодод эрхэд хүрсэн. Тэдгээр алхам нь түүнийг цөмийн зэвсгийн үйлдвэрлэлд ашиглаж болох тоног төхөөрөмж, технологийг нь дамжуулахгүй, тараахгүй байх дэгийг сахихыг шаардсан АНУ-ын сонирхолтой удаа дараа мөргөлдөхөд хүргэж байна. Сүүлчийн жишээ гэхэд хоёр жил дамжин яригдсаны дараа Барууны ашиглагдсан ураныг Орост “оршуулах” төслийг Төрийн Дум нь зөвшөөрсөн. Түүний хариуд Минатом нь 20 тэрбум ам.доллар хүртэж байгаа ажээ. Олон нийтийн зүгээс нэлээн эсэргүүцэлтэй тулгарсан хэдий ч “маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушиг” гэгч болжээ. 2000 оны байдлаар 120 тэрбум квт.цаг эрчим хүчийг атомын цахилгаан станцуудад үйлдвэрлэсэн.

Металлургын салбар нь аль болох худалдааны барьерыг хурдан авч хаяад Баруунтай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэхийн төлөө үзэж байна. 1990-ээд оноос тэрээр өөрийн бүтээгдэхүүний хагасаас илүүг гадагш нь зарж Оросын аж үйлдвэрийн дотроос хамгийн их экспортын чиглэлтэй хэмээгдэх болсон. ОХУ нь Дэлхийн худалдааны байгууллагад элсэх нь АНУ болон ЕХ-ны протекционизмыг даван туулахад түлхэц болох учиртай. Зөвхөн өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэлийн жилийн эргэлт нь 2001 оны байдлаар 11 тэрбум америк долларт хүрч түүнийхээ 9 тэрбум америк доллартай тэнцэх хэмжээний бүтээгдэхүүнээ экспортлосон.

Дэлхийн худалдааны байгууллага гэдэг нь дэлхийн хэмжээний худалдааны глобал системийн үндэс бөгөөд ОХУ нь энэ системд хамрагдах зайлшгүй шаардлагатай. Учир нь ОХУ антидемпингийн шинжтэй янз бүрийн төрлийн санкцуудаас жил бүр 1 тэрбум орчим ам. доллар алдсаар байна(3). Зөвхөн 1992-1997 онуудад Европын Холбооноос ОХУ-ын хувьд 11 удаа антидемпингийн мөрдлөгө хийсэн ба эдгээр нь голдуу бордоо, химийн янз бүрийн бодисууд, залгаасгүй төмөр хоолой зэрэгт хамрагдаж байсан.

1999 оны байдлаар ХБНГУ 1695,1 сая ам.доллар, АНУ 2920,6 сая ам.доллар, Англи 733,6 сая ам.доллар, Франц 312,2 сая ам.доллар, Голланд 540,7 сая ам.доллар, Финлянд 247,7 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг тус тус хийсэн байна. Нийт хөрөнгө оруулалтын 80,9 хувийг европын хөгжилтэй орнууд эзэлдэг (4).

ОХУ-ын том бизнесийн салбаруудыг үндсэнд нь 6 бүлэгт хуваагаад тэдгээрийг харьцуулж харуулбал доорхи тоймыг гаргаж болох юм (5).

Секторууд	Байгалийн хийн салбар	Эрчим хүчний салбар	Нефтийн салбар	Төмөрлөгийн салбар	Цөмийн салбар	Цэрэг-аж үйлдвэрийнхэн "ВПК"
Дотоод зохион байгуулалт ба үндсэн өгөгтүүд	Дөнгөөр нөврөх эрхтэй. Тухайн салбар нь дээд зэргээр зохион байгуулагдаж, төвлөрсөн удирдлагад орсон. Агентүүд: РАО "Газпром", түүний охин компаниуд	Төрөлхийн монопол эрхтэй. Салбарын удирдлага ихээхэн зохион байгуулагдан төвлөрсөн. Агентүүд: РАО "ЕЭС", бүс нутгийн эрчим хүчний ситемүүд, Росэнергоатом бол бие давсан 4 том компанитай: Иркутскэнерго, Новосибирскэнерго, Татэнерго, Башэнерго. Европ чиглэлд зөвхөн РАО "ЕЭС" идэвхитэй байгаа.	Өөр хоорондоо өрсөлддөг 4 мөн зохицуулагддаг маш олон төрийн эрчим хүчний салбар. Агентүүд: 12 том компанитай ба тэдгээрээс ЛУКОЙЛ, СУРГУТНЕФТЕГАЗ, СЛАНЕФТЬ, ТРАНСНЕФТЬ 4 л гадаад бодлогод нөлөөтэй.	Уг салбарын элитууд нь маш олон янз. Өнгөт төмөрлөгийнхөн экспортын чиглэлд гол анхаарлаа хандуулж байхад хартөмөрлөгийнхөн дотоод гадаад зах зээл рүү хандсан. Агентүүд: 1700 үйлдвэрүүд, тэдний дотроос томоохон нь Тгае World Group, Норильский никель, МИКОМ, Ранова, Алюминь- продукт, (Севарсталь, Новалипецкий, Магнитогорский МЗ, Саянский, КрАЗ, БрАЗ)	Цэрэг ба иргэний холимог элитуудээс бүр- дэх уг салбарт сүүлийн үед иргэний нөлөө нэмэгдэж буй. Төв ба бүс нутгийн хооронд зөрчилтэй дээд зэргээр төвлөрсөн удирдлагатай хуучны бүтэц нь хэвээр байгаа. Агентүүд: Минатом, Госатомнадзор.	Нэгдмэл элит үгүй, сансар нисэх мэтийн өндөр технологийн үйлдвэрүүд нь хоорондоо төврдөггүй. Агентүүд: Гадаадтай цэрэг техникийн асуудлаар хамтран ажиллах улсын хсрээс(КВТС РФ) БХА-дэрлэхэд эдийн засгийн хороод (Рособоронэкспорт, МАПО, КБ Сухого, ФПГ"оборонительные системы", Антей, ФПГ"Морская техника", ВПК-г дэмжих олон нийтийн холбоо, хуви хүмүү-сийн зүгээс Сижков, Глазьев, Маслюжас, Клебанов г.м.
Нөөц	Байгалийн хийн нөөцөөр дэлхийд томд орох ба ОХУ,бол ТУХН, Дорнод ба Баруун Европ, Туркээр хий дамжуулах хоолойн сүлжээтэй ба шинэ ордыг азмших, шинэчлэхэд зохих нөөц бололцотой.	Нийгэм эдийн засгийн хүрээнд ихээхэн ажлыг нугалдаг, гадаадынхан хувьцаа азмшигчдийн бүрэлдэхүүнд багтдаг учир РАО-н удирдлагад манээр хийх боломж илүү хуучин ЭХТЗ-ийн гишүүн орнуудад нөлөөтэй.	Нефтийн экспортоор одоохондоо дэлхийд эхний төвд багтдаг, түүхий эдийн ихээхэн нөөцтэй, үндсэн фондоо шинэчлэх шаардлагатай (түүнд нь өөрийн хангалттай нөөц үгүй)	Дэлхийн зах зээлийн 10%-г эзэлдэг төмөрлөгийн томоохон аж үйлдвэртэй, ОХУ-ын экспорт руу чиглэлтэй аж үйлдвэрийн том сектор. Эрчим хүчний болон төмөр замын гол түнш, бүс нутгийн дэд бүтцийн хөгжлийг дэмждэг гол салбар.	ОХУ-ыг их гүрний статустай байлгах наг гол үндэс. ОХУ болон ТУХН, Төв ба Дорнод Европ, Финляндэд сүлжээтэй.	Эдийн засгийн томоохон өвлбарын наг голдуу халттай хотуудад байрладаг, ОХУ-ын их гүрний бэлэг тэмдэг болсон, гуравдахь өртөнцөд ихээхэн нөлөөтэй салбар.
Улс төрд тэдний байр	Улсын компани хэмээн нэр төдий тосгог-дох ба РАО нь эдийн засаг нийгмийн прог-ремнуудыг хэрэгжүүлэх гол эх сурвалжийн нэг. 1998 он хүртэл уг салбар-ын удирдлага засгийн газраас шууд хөмөөрч байсан.	Сүүлийн жилүүдэд РАО-н улс төрийн байр суурь нэлээд нэмэгдсэн ч үндсэн нөлөө нь бүс нутгийн хэмжээнд байсаар байгаа учир эрчим хүчний ихээхэн нөөц нь Урал Сибирьт оршдог.	Холбооны ба бүс нутгийн хэмжээнд сайн зохион байгуулагдсан лоббитэй, өндөр хэмжээнд дотооддоо өрсөлдөөнтэй, бүтцийн өөрчлөлт хийх процесс дуусаагүй, холбооны болон бүс нутгийн	Бүс нутгийн болон холбооны хэм-жээнд уламжлал бүхий зохион бай-гуулалттай лобби-тэй, уг салбарын захиралуудын зөвлөл идэвхитэй үүрэгтэй мөн Төрийн Дум, улс төрийн нам хөдөлгөөнийг бий болгон дэмжиж байгаа (А.Тулеевын блок, Вся Россия, Голос	ЗХУ-ын үеийн-хэвс ихээхэн бага болсон хэдий ч засгийн газар, өрөнхийлөгчийн тамгын газарт нөлөөгөө хадгалсаар байгаа. Бүс нутаг нөлөө нь	Сүүлийн жилүүдэд ВПК-н жин улс төрд ихээхэн нэмэгдсэн ЕТГ, Засгийн газарт, Төрийн Дум, Холбооны зөвлөлд ихээхэн тогтвортой бат Бөх байр суурьтай. Энэ нь НАТО Югослав руу дайрсны дараа лобби нь хүчээ авсан, мөн чечений II дайн эхэлснээр, Путин өрөнхийлөгч болсноор, хүчний байгууллагуудын байр суурь нэмэгдсэнээр улам гаврсан.

оуурь	Захиралуудын зөвлөлд Ерөнхийлөгчийн тамгын газраас хун ордөг.		захиргаанаас хараат	Росси, Яблоко]	тийм ч хүчтэй бус.	
Дотоод сонирхол	ОХУ-ыг хүчирхэг бөгөөд дахин задруулахгүй байлгах сонирхолтой ба ерөнхийдөө зах зээлийн өөрчлөлтийг дэмждэг.	Хүчтэй улсаа хадгалан ОХУ-ыг задлахгүй байж зах зээлийн эдийн засгийг дэмжин тухайн салбараа шинэчлэхэд дэмжлэг хүлээж суугаа.	Хийн салбарыг бодвол илүү либерал, гадаад худалдаан дахь төрийн оролцоог аль болох багасгахын төлөө байдаг.	Эдийн засгийг либералчлахын төлөө үздэг, бус нутагт ихээхэн нөлөөтэй, эрүүгийн ертөнцөд ихээхэн хутгалдсан нь түүний улс төрийн чиглэлийг тодорхойлоход төвөгтэй.	Нэлээн консерватив үзэлт чиглэлийн нэг ба элитүүдийн зарим нь улсын хяналтыг хүчтэй болгохыг дэмждэг байхад нөгөө хэсэг нь зах зээлд зохицохыг оролдож байгаа.	Хүчтэй улсаа хадгалж, түүнийг задрахыг үл тэвчих, Эли-түүд нь ерөнхийдөө 2 хуваагддаг. Үүнд: улсын захиалгаа нэмэгдүүлж хуучнаа сэргээх, нөгөө хэсэг нь зах зээлийн эдийн засагт зохицох. Мөн улс төрийн Зүүний хүчний дэмжлэгийг хүлээж байдаг.
Гадаад сонирхол	Гадаад дахь гол зах зээл нь Баруун Европ тухайлбал, ХБНГУ мөн Турк. Тиймээс ЕХ-той ойртохын төлөө байдаг. Мөн хийг дамжуулан өнгөрүүлэх үл-сууд болох Молдов,Польш, Финлянд зэрэгтэй сайн харилцаатай байх шаардлагатай байдаг. Ерсөл-дөгчөө саврамаг-жуулах үүднээс Казяхстан, Турменстан, Узбекстан зэргийг өөрийн системд интег-рацлах сонирхолтой	Балтийн улсууд Төв, Дорнод Европын орнуудтай нягт харилцан ажиллагдаатай байж Скандиновын орнуудтай харил-цавг хөгжүүлж ЕХ-ны эрчим хүчний зах зээлийг либералчлах сонирхолтой	Мөн хийн салбарыг бодвол ЕХ-той илүү бага холбогдсон хэдий ч тэдний зээл, хөрөнгө оруулалтыг горьдож суудаг.	Экспортыг нэмэгдүүлж ЕХ болон АНУ-ын протекционизмыг даван туулах салбарынхаа технологийн шинэч-лэлийг хийхийн тулд гадны хөрөнгө оруулалтыг татах сонирхолтой	Гадаад АЭС барих, үйлчил-гээ хийх, техно-логи экспорт-лох, гадны ашиглагдсан тулш оруулж ирж хадгалах (дарх) гадагшаа оосун ухаан "экспорт-лохыг" хязгаар-лах, ОХУ-ын АЭС-ыг шинэч-лэх, аюулгүй байдлыг өндөр-жүүлэхэд гадны хөрөнгө оруу-лалт хийх	Франц болон Израильтай цэрэг-технидийн төслүүдэд хамтран оролцох оролдлого, Хятад, Энэтхэг, Малайз, Турк зэрэг болон гуравдахь ертөнцийн орнуудтай хамтын ажиллагаагаа ихээхэн өргөжүүлэхийг хүсэн, зүтгэж байгаа.
Монголд нөлөөтэй эсэх	үүгүй	Буриадын Гусноазерскийн д.ц.с эрчим хүчийг хэрэглэдэг	Жилд дунджаар 40 гаруй сая ам. долларын нефть бүтээгдэхүүн авдаг	үүгүй	үүгүй	үүгүй

## Дүгнэлт:

- |    |    |    |    |    |    |    |    |
|----|----|----|----|----|----|----|----|
| I. | I. | I. | I. | I. | I. | I. | I. |
|----|----|----|----|----|----|----|----|
1. Монгол улс нь нефтийн 40 сая, бага хэмжээний эрчим хүчийг эс тооцвол Оросын талын том бизнесийн сонирхолд хараахан өртөөгүй байгаа зах зээл.
- |     |     |     |     |     |     |     |     |
|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|
| II. | II. | II. | II. | II. | II. | II. | II. |
|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|
2. ОХУ-ын том бизнесийнхний Азийн зах зээл рүү тухайлбал Хятад, Зүүн Өмнөд Азийн орнуудтай түншлэх бодлогод Монгол улсын газар нутгийг дамжин өнгөрүүлэх хэмжээнд ашиглах нь эдийн засгийн хувьд хэрэгтэй зүйл.
- |      |      |      |      |      |      |      |      |
|------|------|------|------|------|------|------|------|
| III. | III. | III. | III. | III. | III. | III. | III. |
|------|------|------|------|------|------|------|------|
3. Оросын эдийн засгийг үндсэндээ авч явж буй дээрхи салбаруудын ашиг сонирхол хаана хүчтэй байна тэнд гадаад бодлого нь ч идэвхжих нь зайлшгүй.

## Эх сурвалж:

- |    |    |    |    |    |    |    |    |
|----|----|----|----|----|----|----|----|
| I. | I. | I. | I. | I. | I. | I. | I. |
|----|----|----|----|----|----|----|----|
1. Перспективы развития экономики России. М., 2000, С.69.
- |     |     |     |     |     |     |     |     |
|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|
| II. | II. | II. | II. | II. | II. | II. | II. |
|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|
2. Мөн тэнд С.67.
- |      |      |      |      |      |      |      |      |
|------|------|------|------|------|------|------|------|
| III. | III. | III. | III. | III. | III. | III. | III. |
|------|------|------|------|------|------|------|------|
3. Московский журнал международного права. 1999. №1. С.96-109.
- |     |     |     |     |     |     |     |     |
|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|
| IV. | IV. | IV. | IV. | IV. | IV. | IV. | IV. |
|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|
4. Перспективы развития экономики России. М., 2000, С.112.
  5. ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2001 оны №1959 тушаал "ОХУ-ын гадаад орнуудтай цэрэг техникийн хамтын ажиллагааны тухай" Дипломатический вестник, 2000 он, № февраль. С.58-65.